



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/662


Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.12, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгдийн Хурлын 2019 оны “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төвийн аж ахуйн нэгж, төсөвт байгууллага, татвар, ниймийн даатгалын салбарын санхүү, бүртгэлийн ажилтнуудын дунд зохион байгуулах “Татварын хууль тогтоомж, эрх зүй, бүртгэл, тайлагнал, практик хэрэглээ” сэдэвт сургалтын дэмжлэгт 2000.0 мянган төгрөг /хоёр сая/-ийн төсвийг хавсралтаар баталж, зарцуулсугай.


2. Үйл ажиллагаанд зарцуулах 2.0 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний 5.8-д заасан хөтөлбөр, арга хэмжээнээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.



ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны
11 дүгээр сарын 05-ны өдрийн
А/662 дугаар захирамжийн хавсралт



“ТАТВАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ЭРХ ЗҮЙ, БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ,
ПРАКТИК ХЭРЭГЛЭЭ” СЭДЭВТ СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ДҮН

д/д	Үзүүлэлт	Тоо	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /мянган төгрөг/
1.	Багш нарын унааны зардал	2	179500.00	359.0
2.	Багш нарын байрны зардал	4	85000.00	340.0
3.	Сургалтын заалны зардал	1	500000.00	500.0
4.	Завсарлагааны цай	150	3000.00	450.0
5.	Зар сурталчилгаа, бичиг хэргийн зардал		200000.00	200.0
6.	Увс аймаг хүргэх шатахууны зардал	480 км/97л	1560.00	151.0
	Дүн			2000.0

-оОо-